

“Алгебрын илэрхийлэл, тэгшитгэл” нэгжийн

даалгавар 6-р анги

1. 800 төгрөгний үнэтэй 4 зайрмаг, тус бүр нь 3500 төгрөгний үнэтэй n ширхэг элгэн тараг зэргийг худалдан авахад ямар үнэтэй болохыг илэрхийлэл зохиож, хариуг нөхөж бичээрэй.

2. Илэрхийллийг хялбарчлаарай. $4x + 6y - x - 7y - 3x - y =$
a. $x - y$ b. $-y$ c. $-2y$ d. 0
3. Илэрхийллийг хялбарчилж, илэрхийллийн тоон утгыг олоорой.
 $b = -2$ үед $-5a + 6b + 2a - 8b + 3a =$
a. -4 b. 4 c. -28 d. 28
4. Илэрхийллийг хялбарчлаарай.
 $-6 \cdot (4 - 5x + y) =$
a. $-24 + 30x - 6y$ b. $-24 - 30x - 6y$ c. $24 + 30x - 6y$ d. $-24 + 30x + 6y$
5. Хаалтнаас ерөнхий үржигдэхүүнийг гаргаарай.
 $14x - 7y + 28 =$
a. $7 \cdot (-2 - y + 4)$ b. $14 \cdot (1 - y + 4)$ c. $7 \cdot (2x + y - 4)$ d. $7 \cdot (2x - y + 4)$
6. Гишүүнчлэн үржүүлж, илэрхийллийг хялбарчлаарай.
 $-8 \cdot (3a - 2b) - 2 \cdot (-4b + 3a) =$
a. $-18a + 24b$ b. $-32a - 10b$ c. $-30a + 24b$ d. $-16a + 10b$
7. Тэгшитгэлийг бодож x үл мэдэгдэхийг олоорой
 $-3x + 7x - 10x = 84$
a. 4.2 b. -4.2 c. -14 d. -6
8. Тэгшитгэлийг бодож x үл мэдэгдэхийг олоорой
 $125 : (2x - 7) = 5$
a. 9 b. 16 c. 32 d. 36
9. Тэгш өнцөгтийн өргөн нь уртаасаа 6м-ээр богино бөгөөд тэгш өнцөгтийн периметр 72м бол тэгш өнцөгтийн урт ба өргөнийг олоорой.
a. 24, 12 b. 22, 14 c. 20, 16 d. 21, 15
10. Шалны урт 7 ширхэг хавтангийн уртаас 60 см-ээр илүү байв. Хэрэв хавтангийн урт x см бол тасалгааны уртыг ол.